

Халдварт өвчний өнөөгийн байдал, хяналтыг  
сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар “Халдварт өвчний өнөөгийн байдал, хяналтыг сайжруулах” талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Энхтүвшингийн илтгэлийг хэлэлцээд **ШИЙДВЭРЛЭСЭН** нь:

Монгол Улсын Засгийн газарт:

1. “Дархлаажуулалтын тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, вакцины нийлүүлэлт, эм, хүнсний зохицуулалтын бие даасан алба байгуулах, хөндлөнгийн хяналтыг тодорхой болгох, зарим эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин тоног төхөөрөмжийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрүүдээс шууд худалдан авах тогтолцоог бүрдүүлэх, улсын хэмжээнд вакцин, биобэлдмэлийн хөндлөнгийн хяналтын лаборатори байгуулах, төрийн хяналтыг чангатгах, хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх,

2. Биотехнологийн цогцолбортой болох, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн биотехнологи, иммуноглобулины үйлдвэрлэлийг дэмжих, товлолын бус вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой байгаа улсын байгууллага болон хувийн аж ахуйн нэгжийг төрийн зүгээс анхаарч, хууль, эрх зүйн хувьд дэмжин, хамтран ажиллах,

3. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нэгдсэн лабораторид био-хамгаалал, био-аюулгүй ажиллагааны гуравдугаар зэрэглэлийн шаардлага хангасан лабораторийг байгуулж, манай улсад бүртгэгдээд байгаа хүний болон шувууны томуу, амьсгалын замын цочмог халтай хам шинж (SARS) болон шинээр гарч буй аливаа халдварын үүсгэгчийг тодорхойлох чадвартай болох.